

## ИННОВАЦИЙН ТӨСӨЛ БҮРТГЭХ ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Энэхүү журмаар инновацийн бүтээгдэхүүн, үйлчилгээг зах зээлд нийлүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэгчийн инновацийн төслийг хүлээн авах, үнэлгээ дүгнэлт гаргах, бүртгэх түүнтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулна.
- 1.2. Инновацийн төсөл /цаашид “Төсөл” гэх/ нь Инновацийн тухай хуулийн 4 дүгээр зүйлд заасан инновацийн үйл ажиллагааны зарчимд нийцсэн байна.
- 1.3. Төслийг Монгол Улсад бүртгэлтэй өмчийн бүх хэлбэрийн үйлдвэр, аж ахуйн нэгж, эрдэм шинжилгээний байгууллага, иргэн дэвшүүлж болно.
- 1.4. Төсөл хэрэгжүүлэх хугацаа 3 хүртэл жил байна.

### Хоёр. Төсөл, түүнд тавигдах шаардлага

- 2.1. Төслийг бүртгэхдээ дор дурдсан зүйлүүдийг багтаасан баримт бичгийг үндэслэнэ:
  - 2.1.1. Төсөл санаачлагчийн төсөл бүртгүүлэх хүсэлт,
  - 2.1.2. Оюуны өмчийн эрхийн баталгаажилт,
  - 2.1.3. Хуулийн этгээдийн гэрчилгээний хуулбар /иргэний үнэмлэх/,
  - 2.1.4. Инновацийн төсөл:
    - а/ төслийн нэр, товч агуулга, танилцуулга;
    - б/ хэрэгжүүлэх хугацаа (эхлэх, дуусах он, сар);
    - в/ төсөл санаачлагчийн нэр, үйл ажиллагааны чиглэл;
    - г/ хэрэгжүүлэх шаардлага, үндэслэл;
    - д/ инновацийн бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр, төрөл, ач холбогдол, хэрэгжих боломж;
    - е/ хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын тооцоо;
    - ё/ бизнес төлөвлөгөө, эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлын талаарх төсөөлөл;
    - ж/ техник, эдийн засгийн үндэслэл.
    - з/ бусад холбогдох материалуудыг хавсаргаж болно.
  - 2.1.5. Төсөл, түүнд хавсаргасан материалын үнэн зөв байдлыг төсөл санаачлагч бүрэн хариуцна.
- 2.2. Төсөл нь Инновацийн тухай хуулийн 14, 15 дугаар зүйлд зааснаас гадна дараах шаардлагыг хангасан байна:
  - 2.1.1. инновацийн тэргүүлэх чиглэлд нийцсэн байх;
  - 2.1.2. бүтээгдэхүүн, үйлчилгээний анхдагч загварыг гаргаж, технологийн туршилт, зүгшрүүлэлт хийсэн байх;

- 2.1.3. оюуны багтаамж буюу технологийн агууламжтай инновацийн бүтээгдэхүүн, үйлчилгээ байх;
  - 2.1.4. төслийн хэрэгжүүлэх маркетингийн болон бизнес төлөвлөгөөг боловсруулсан, зах зээлийн эрэлт хэрэгцээг судалгаанд суурилан тодорхойлсон байх;
  - 2.1.5. өрсөлдөгч бүтээгдэхүүнээс ялгарах давуу тал (техник, технологи, үнэ, өртөг, нэмүү өртөг шингээсэн байдал зэрэг)-уудыг бүрэн нотлог илэрхийлсэн байх;
  - 2.1.6. нэмүү өртөг шингээсэн, үйлдвэрлэлийн үр дүнд бий болсон байх.
- 2.3. Төсөл санаачлагч нь дараах шаардлагыг хангасан байна:
- 2.3.1. төсөл хэрэгжих хугацаанд инновацийн бүтээгдэхүүн, үйлчилгээг зах зээлд гаргах боломжтойг нотолсон байх;
  - 2.3.2. төслийг амжилттай хэрэгжүүлэх хүний нөөц, санхүүгийн чадавхтай байх;
  - 2.3.3. биелэгдэхүйц бодитой зорилго тавьсан байх;
  - 2.3.4. ойлгомжтой ба тодорхой бизнес-загвартай байх;
  - 2.3.5. нэмүү өртгийг бүтээхэд чиглэсэн байх.
  - 2.3.6. төсөл хэрэгжүүлэгч нь төсөлтэй холбоотой санхүүгийн үйл ажиллагааг шинэ данс нээн өөрийн бусад үйл ажиллагаанаас тусад нь хөтөлнө.

#### Гурав. Төсөл мэдүүлэх, бүртгэх, хасах

- 3.1. Өндөр технологи, үндэсний инновацийг хөгжүүлэх асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага төсөл бүртгэх нөхцөл, шаардлагыг тухайн оны гуравдугаар улиралд багтаан олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр зарлана.
- 3.2. Төсөл санаачлагч зарласан нөхцөл, шаардлагын дагуу төслийн баримт бичгийг боловсруулж, Өндөр технологи, үндэсний инновацийг хөгжүүлэх асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тогтоосон хугацаанд цахимаар мэдүүлнэ.
- 3.3. Өндөр технологи, үндэсний инновацийг хөгжүүлэх асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тавигдсан нөхцөл, шаардлагыг бүрэн хангасан төсөлд мэргэжлийн шинжээчдээр үнэлгээ, дүгнэлт гаргуулна.
- 3.4. Төсөлд дүгнэлт гаргах шинжээчийг Өндөр технологи, үндэсний инновацийг хөгжүүлэх асуудал эрхэлсэн засгийн газрын гишүүний баталсан жагсаалтаас сонгоно.
- 3.5. Шинжээч нь төсөлд үнэлгээ өгч, дүгнэлт гаргахдаа энэхүү журам болон өндөр технологи, үндэсний инновацийг хөгжүүлэх асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан "Шинжлэх ухаан, технологи, инновацийн төслийн саналд үнэлгээ өгч, дүгнэлт гаргах аргачлал"-ыг тус тус удирдлага болгоно.
- 3.6. Төсөл нь хуульд заасан шаардлагад нийцэж байгаа эсэх талаарх дүгнэлтийг Өндөр технологи, үндэсний инновацийг хөгжүүлэх асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага шинжээчдийн дүгнэлтэд үндэслэн гаргана.

- 3.7. Дүгнэлтийг үндэслэн Өндөр технологи, үндэсний инновацийг хөгжүүлэх асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Инновацийн төслийг мэдээллийн санд бүртгэнэ.
- 3.8. Өндөр технологи, үндэсний инновацийг хөгжүүлэх асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дүгнэлтийг төсөл санаачлагчид албан бичгээр мэдэгдэнэ.
- 3.9. Өндөр технологи, үндэсний инновацийг хөгжүүлэх асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараах үндэслэлээр төслийг бүртгэлээс хасна.
  - 3.9.1. төсөл хэрэгжүүлэх хугацаа дууссан;
  - 3.9.2. төсөл бүртгүүлснээс хойш нэг жилийн хугацаанд үйл ажиллагаа эрхлээгүй, эрхлэх боломжгүй, төслийн үндсэн чиглэлийг хэрэгжүүлээгүй нь шалгалтаар тогтоогдсон;
  - 3.9.3. хэрэгжүүлэгч байгууллагын зүгээс хүсэлт ирүүлсэн;
  - 3.9.4. байгаль орчин ба хүний эрүүл мэндэд хортой технологи, материал хэрэглэсэн, экологийн хохирол учруулсан, хууль тогтоомж, дүрэм журмыг зөрчсөн нь эрх бүхий байгууллагаар тогтоогдсон.
- 3.10. Төсөл хэрэгжих хугацаа дууссан хэрэгжүүлэгчийн үйл ажиллагааг хэрхэх асуудлыг холбогдох хуулиар зохицуулна.

#### Дөрөв. Хөнгөлөлт, дэмжлэг

- 4.1. Мэдээллийн санд бүртгэгдсэн инновацийн төсөл хэрэгжүүлэгч нь Инновацийн тухай хуульд заасан хөнгөлөлт, дэмжлэгийг эдэлнэ.
- 4.2. Гаалийн татвараас чөлөөлөх; /Гаалийн тариф, гаалийн татварын тухай хууль/
- 4.3. Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх; /Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль/
- 4.4. Газрын төлбөрөөс чөлөөлөх; /Газрын төлбөрийн тухай хууль/
- 4.5. Тендерт оролцогчдод давуу эрх олгох; /Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль/
- 4.6. Ажлын байрны төлбөрөөс чөлөөлөх; /Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хууль/
- 4.7. Инновацийн төслөө грантад дэвшүүлэх; /ЗГ-ын тусгай сангийн тухай хууль/
- 4.8. Гарааны компани байгуулах;
- 4.9. Захиалагч, санхүүжүүлэгчид мэдүүлэх;
- 4.10. Төсөл хэрэгжүүлэхэд хөнгөлөлттэй зээл олгох;
- 4.11. Хууль заасан бусад хөнгөлөлт, дэмжлэг.
- 4.12. Дээрхи дэмжлэгийг аудитийн байгууллагын дүгнэлтийг үндэслэн эдэлнэ.

#### Тав. Төслийн хэрэгжилтэд хяналт тавих

- 5.1. Өндөр технологи, үндэсний инновацийг хөгжүүлэх асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага төслийн хэрэгжилтэд хяналт тавина.

- 5.2. Төсөл хэрэгжүүлэгч нь төслийн хэрэгжилтийн явц болон санхүүжилтийн тайланг жил бүрийн 3 дугаар сард багтаан өндөр технологи, үндэсний инновацийг хөгжүүлэх асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.
- 5.3. Өндөр технологи, үндэсний инновацийг хөгжүүлэх асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага төслийн хэрэгжилтийн явц, үр дүнд хяналт тавих үүрэг бүхий орон тооны бус шинжээчийн багийг ажиллуулж болно.

#### Зургаа. Бусад

- 6.1. Төсөл хэрэгжүүлэгчийн үйл ажиллагааны мэдээллийн нууцлалыг хадгалах, хамгаалах, ашиглахтай холбогдсон харилцааг Төрийн нууцын тухай, Байгууллагын нууцын тухай, Хувь хүний нууцын тухай хуулиар тус тус зохицуулна.
- 6.2. Төсөл хүлээн авах, үнэлгээ дүгнэлт гаргах, бүртгэх үйл ажиллагаатай холбогдох аливаа зөрчил маргааныг Талууд үл маргах замаар шийдвэрлэх бөгөөд тохиролцож чадаагүй тохиолдолд холбогдох хууль тогтоомж болон шүүхээр шийдвэрлэнэ.

--- о О о ---